



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/88

Онги

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн спортын төрлийг нэмэгдүүлэх, иргэдийн бүх нийтийн биеийн тамир спортоор хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгаас Дундговь аймгийн “Бага олимп” спортын наадамд баг тамирчдыг бэлтгэн оролцуулсугай.

2. Спортын наадамд оролцох баг тамирчдыг батлагдсан удирдамжийн дагуу бэлтгэл, зохион байгуулалтын аргазүйгээр хангаж оролцуулахыг Засаг даргын орлогч (Ц.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3. Дундговь аймгийн “Бага-Олимп” спортын наадамд оролцоход шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

4. Дээрх төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Төсвийн шууд захирагч (С.Болоржаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 7/а дугаар захирамжийн хавсралт

/мян.төг/

ТӨРӨЛ	ТАМИРЧДЫН ТОО	ШАТАХУУНЫ ЗАРДАЛ	ХООЛНЫ ЗАРДАЛ	БООЦОО	ХУВЦАС ЖИГДР ЭЛТ, ЛОГО ХЭВЛЭЛ	НИЙТ
САГСАН БӨМБӨГ	8эм,8эр	3 машины шатахуун 624.0	600.0	1,000.0	2,776.0	5,000.0
ГАР БӨМБӨГ	10эр,10эм					
ДАРТС	1эр, 1эм					
ТЕННИС	1эр, 1эм					
ШАТАР	1эр, 1эм					
ДААМ	1эр,1эм					
БАДМИ Н	1эм					
БУУДЛА ГА	1эр,1эм					
ШАГАЙ Н ХАРВАА	8эр					
ДҮН	55	624.0	600.0	1,000.0	2,776.0	5,000.0